



“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Огноо 2018.04.26

Дугаар 01

Улаанбаатар хот

Хурал хүчин төгөлдөрт тооцох тухай

Компанийн дүрмийн 7.4 зүйл, Хувьцаа Эзэмшигчдийн XXV хурлаас **ТОГТООХ** нь:

1. Баянгол Зочид Буудал ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн XXV-р хуралд 423065ш хувьцааг эзэмшсэн 1080 хувь нийлүүлэгчдээс, ирсэн 305328ш хувьцаа эзэмшдэг 126 хувь нийлүүлэгч нь нийт хувьцааны 80,1 хувь болсон тул Компанийн тухай хуулийн 69.1 зүйл, Компанийн дүрмийн 7.4 зүйлийг үндэслэн хурлыг хүчин төгөлдөрт тооцон хуралдуулсугай.

ХУРЛЫН ДАРГА



/Б.АЮУШ/



“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Огноо 2018.04.26

Дугаар 02

Улаанбаатар хот

ДҮГНЭЛТ, ТӨСӨВ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62.1.9 зүйл, Хувьцаа Эзэмшигчдийн XXV хурлын Тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг 99.5 хувийн саналаар баталсугай.
2. Компанийн ТУЗ-ын зардлын төсвийг 99,5 хувийн саналаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА/Б.АЮУШ/





“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Огноо 2018.04.26

Дугаар 03

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62.1.7, 77.1 зүйл, Хувьцаа Эзэмшигчдийн ХХV хурлын Тооллогын комиссын 03 дугаар тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр дараах нэр бүхий 6 хүнийг сонгосугай.

- 1/ Х.Баттуул-304,425 санал
- 2/ Билли Лим Сим Пау - 304,159 санал
- 3/ М.Золжаргал – 304,062 санал
- 4/ Ц.Хэнмэдэх – 304,050 санал
- 5/ Х.Цэндбаяр – 304,213 санал
- 6/ З.Цэрэнчимэг -304,100 санал

2. Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр дараах нэр бүхий 3 хүнийг сонгосугай.

- 1/ Б.Аюуш – 304,186 санал
- 2/ Д.Батжаргал – 304,218 санал
- 3/ Д.Цэнддорж – 304,090 санал

3. Компанийн тухай хууль болон компанийн дүрэм холбогдох дотоод журмаар тогтоосон бүрэн эрхээ зохих ёсоор хэрэгжүүлж компанийн эрх ашгийн төлөө мэдлэг чадвараа дайчлан ажиллахыг ТУЗ-ийн гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА/Б.АЮУШ/





**“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

Огноо 2018.04.26

Дугаар 01

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн тухай болон
хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай

Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.4 дэх заалт, 67 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1.Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн хуралд 236'271 хувьцаа эзэмшдэг 125 хувьцаа эзэмшигч биеэр оролцож байгаа, 69'057 хувьцаа эзэмшдэг 1 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар саналаа ирүүлсэн нь нийт гаргасан энгийн хувьцааны 80.1 хувь болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.

2. Компанийн тухай хуулийн 69.4 дэх хэсгийн заалт болон компанийн дүрмийн 7.4 заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 80.1 хувийг эзэмшигчид хуралд оролцож байгаа учраас компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

КОМИССЫН ДАРГА





**“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

Огноо 2018.04.26

Дугаар 02

Улаанбаатар хот

Санал хураах хуудсыг тоолсон
дүнгийн тухай

Компанийн тухай хуулийн 62.1.9, 63.5 болон 67.3.8 дах заалтыг үндэслэн
ТОГТООХ НЬ:

1.Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлуудаар санал хураасан дүн
дараах байдалтай байгааг хуралд оролцогчдод мэдээлсүгэй:

1.1. 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-
ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах асуудлаар нийт өгсөн саналын тоо 305'328 үүнээс
зөвшөөрсөн 303'847, татгалзсан 5, түдгэлзсэн 321 нийт саналын эрхийн 99,5
хувийн саналаар уг шийдвэрийг баталсан байна.

КОМИССЫН ДАРГА



/ Т. Бүтүгмаа /



**“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН
ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

Огноо 2018.04.26

Дугаар 02

Улаанбаатар хот

Санал хураах хуудсыг тоолсон
дүнгийн тухай

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дах заалт, 72 дугаар зүйл, санал хураах хуудсыг тоолсон дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1.Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлуудаар санал хураасан дүн дараах байдалтай байгааг хуралд оролцогчдод мэдээлсүгэй:

ТУЗ-ийн Ердийн гишүүнд нэр дэвшигчдийн авсан саналын тоо:

1. Х.Баттуул	304,425 санал
2. Билли Лим Сим Пау	304,159 санал
3. М.Золжаргал	304,062 санал
4. Ц.Хэнмэдэх	304,050 санал
5. Х.Цэндбаяр	304,213 санал
6. З.Цэрэнчимэг	304,100 санал

ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн авсан саналын тоо:

1. Б.Аюуш	304,186 санал
2. Д.Батжаргал	304,218 санал
3. Д.Цэнддорж	304,090 санал

тус тус авсан тул ТУЗ-ийн гишүүдээр сонгосугай.

2. ТУЗ-ийн төсвийг батлах асууллаар санал хураасан зөвшөөрсөн 303,827 санал, татгалзсан 1 санал, түдгэлзсэн 340 санал, нийт саналын эрхийн 99,5 хувийн саналаар дэмжсэн байна.

КОМИССЫН ДАРГА



Т. Бигийаа